



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрийн явган болон авто зам, нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийн шон дээрх цахилгааны утаснуудын холболт, интернэтийн болон үүрэн холбооны шилэн кабелиуд нь цахилгаан техникийн аюулгүй ажиллагааг хангаж байгаа эсэхэд шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, хяналт шалгалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2 дугаар, шаардагдах зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хяналт шалгалтын ажлыг 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс 01 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авахыг ажлын хэсгийн ахлагч (С.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгээр явах унааны зардал, шаардлагатай зардлын тооцоог хавсралтаар баталж шаардагдах 1,300,000 (Нэг сая гурван зуун мянга) төгрөгийг дүүргийн Тамгын газрын төсвөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг дүүргийн Менежер (Д.Баярсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.БАТТӨР

9023190756  
9091904 = CB7327\*



Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
2026 оны 01. дугаар сарын 26-ны өдрийн  
А/СЗ. дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс

Онцгой байдлын хэлтэс

Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах төв

"УБЦТС" ТӨХК-ийн СХХҮТ-ийн Тоолуур, техник үйлчилгээний 1, 2 дугаар хэсгийн инженер

"Захиалагчийн ажлын алба" ОНӨААТҮГ-ын инженер

"Филипс гэрэлтүүлэг" ХХК-ийн инженер

"Их хотын гэрэл" ХХК-ийн инженер

"Цацрах хангай" ХХК-ийн инженер


"Эрчим Өгий" ХХК-ийн инженер

43 хорооны Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн гэрэлтүүлэг, камер, хаяг, рекламны байгууламж хариуцсан мэргэжилтэн


Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
 2026 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн  
 А/С/2 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Ажлын хэсгийн хурал хийж, чиг үүрэг, чиглэлийг хувиарлах	01 дүгээр сарын 19-ний өдөр	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
2	Дүүргийн нутаг дэвсгэрийн явган болон авто зам, нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийн шон дээрх цахилгааны утаснуудын холболт, интернэтийн болон үүрэн холбооны шилэн кабелиуд нь цахилгаан техникийн аюулгүй ажиллагааг хангаж байгаа эсэхэд шалгалт хийх	01 дүгээр сарын 19, 20, 21, 22, 23-ны өдрүүдэд	Ажлын хэсэг
3	Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн шонг засварлах, шатсан гэрлүүдийг солих, шонгийн ил задгай утсыг далдлах, шонг тагжуулах	01 дүгээр сарын 26, 27, 28-ны өдрүүдэд	Гэрэлтүүлгийн ашиглагч байгууллагууд
4	Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж танилцуулах	01 дүгээр сарын 26, 27, 28-ны өдрүүдэд	Ажлын хэсэг
5	Хийгдэж байгаа ажлын явцын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийх	01 дүгээр сарын 19, 23, 26, 30-ны өдрүүдэд	Хороодын Засаг дарга нар, Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах төв
6	Хийсэн ажлын мэдээг нэгтгэн дүүргийн Засаг дарга, Засаг даргын тамгын газрын даргад танилцуулж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх	01 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд	Ажлын хэсгийн ахлагч

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
 2026 оны .01. дугаар сарын 26-ны өдрийн  
 А/С.1. дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



ШАТАХУУН БОЛОН ХЯНАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

9023100756  
 9091904 - CST23271

№	Хэлтэс, албадын нэр	Зардал	Олгох шатахууны хэмжээ (төг)	Зориулалт
1	Дүүргийн Менежер Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс	10 өдөр	100,000	Ерөнхий хяналт
2	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв	10 өдөр	100,000	Ажлын явц үр дүнгийн талаар ТВ, радиогоор олон нийтэд хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах
3	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	10 өдөр	300,000	Бүх хороодоор хяналт тавьж ажиллах унааны зардал
4	Нэгдүгээр ажлын хэсэг	10 өдөр	200,000	"Филипс гэрэлтүүлэг" ХХК-ийн хариуцсан хэсэгт хяналт тавьж ажиллах унааны зардал
5	Хоёрдугаар ажлын хэсэг	10 өдөр	200,000	"Эрчим Өгий" ХХК-ийн хариуцсан хэсэгт хяналт тавьж ажиллах унааны зардал
6	Гуравдугаар ажлын хэсэг	10 өдөр	200,000	"Цацрахангай" ХХК-ийн хариуцсан хэсэгт хяналт тавьж ажиллах унааны зардал
7	Дөрөвдүгээр ажлын хэсэг	10 өдөр	200,000	"Их хотын гэрэл" ХХК-ийн хариуцсан хэсэгт хяналт тавьж ажиллах унааны зардал
ДҮН			1,300,000	